



ҮНДЭСНИЙ УРЛАГИЙН ИХ ТЕАТРЫН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 01 өдөр


Дугаар 02

Улаанбаатар хот

Байгууллагын дүрэм, хөдөлмөрийн  
дотоод журмыг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 129 дүгээр тогтоол, БСШУС-ын сайдын 2016 оны А/136 дугаар тушаал, БСШУСЯ-ны 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 5/3505 дугаар албан тоот зэргийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Үндэсний урлагийн их театрын дүрмийг 1-р хавсралтаар, хөдөлмөрийн дотоод журмыг 2-р хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан дүрэм, журмыг нийт ажиллагсад, уран бүтээлчдэд таниулах ажлыг зохион байгуулахыг дэд захирал /Х.Энхбат/, уран сайхны удирдагч /А.Цэдэн-Иш/ нарт тус тус үүрэг болгосугай.



ЗАХИРАЛ

Г.ЦОГГЭРЭЛ

Үндэсний урлагийн Их театрын  
захирлын 2017 оны 02 сарын 04 өдрийн  
02 тоот тушаалаар батлав.  
ХАВСРАЛТ № 01



## МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ УРЛАГИЙН ИХ ТЕАТРЫН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Монгол Улсын Үндэсний Урлагийн Их театр /цаашид Их театр гэх/ нь бүх нийтэд соёл, урлагаар үйлчлэх зорилго бүхий Монгол Улсын төрийн өмчит соёл, урлагийн төв байгууллага мөн.
- 1.2 Төрийн өмчийн мэргэжлийн урлагийн байгууллагын нийтлэг чиг үүрэг, тэдгээрийг хэрэгжүүлэх, удирдлага зохион байгуулалтыг тодорхойлж, үйл ажиллагааны үндсэн харилцааг зохицуулахад энэхүү дүрмийн зорилго оршино.
- 1.3 Төрийн өмчийн мэргэжлийн урлагийн байгууллага гэдэгт төрийн болон орон нутгийн төрийн өмч бүхий, төрөөс санхүүжилт авч мэргэжлийн баг бүрдүүлэн үйл ажиллагаа явуулж, уран бүтээл туурвиж, соёл, урлагийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагыг хэлнэ.
- 1.4 Их театр нь “Соёлын тухай”, “Соёлын өвийг хамгаалах тухай”, “Төсвийн тухай”, “Авилгын эсрэг”, “Шилэн данс”-ны болон бусад холбогдох хууль тогтоомж, Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан эрх зүйн баримт бичиг, энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.
- 1.5 Их театр нь Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 129 дүгээр тогтоолын дагуу Монгол хэл дээр “Монгол Улсын Үндэсний урлагийн их театр” /товчлол нь МУҮҮИТ/ гэж бичигдэх бөгөөд гадаад харилцаанд “Grand Theatre of National Art of Mongolia” буюу “Mongolian Grand Theatre of National Art”/товчлол нь MGTNA /гэж бичигдэнэ.
- 1.6 Их театр нь хуулийн этгээд бөгөөд Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар”-ын дагуу тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, банкинд харилцах данс, өөрийн онлцог, түүхэн уламжлалыг илэрхийлсэн бэлгэдэлтэй байна.
- 1.7 Мэргэжлийн урлагийн байгууллага нь “Мэргэжлийн урлагийн байгууллагын орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага “MNS 64:2014 стандартыг хэрэгжүүлнэ.
- 1.8 Их театр нь 14251 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Үндэсний Урлагийн их театрын байранд байрлана.

### Хоёр. Үйл ажилгааны нийтлэг чиг үүрэг

Их театр нь дор дурдсан нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.1 Мэргэжлийн урлагийн байгууллага нь төрөөс соёлын талаар баримтлах бодлого, улс, орны хөгжлийн хэтийн төлөвтэй уялдуулан байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг урт болон дунд хугацаанд төлөвлөж батлан хэрэгжүүлнэ. Хөтөлбөрт дараах асуудлыг тусгасан байна. Үүнд:

- 2.1.1 Байгууллагын удирдлага зохион байгуулалтын төлөвлөлт, хэрэгжилт
- 2.1.2 Урын сангийн төлөвлөлт, хэрэгжилт /бүтээгдэхүүн, үйлчилгээний бодлого/
- 2.1.3 Маркетингийн төлөвлөлт хэрэгжилт
- 2.1.4 Хүний нөөцийн төлөвлөлт, хэрэгжилт
- 2.1.5 Төр, хувийн хэвшил, олон нийтийн нийгмийн түншлэлийг хөгжүүлэх төлөвлөлт хэрэгжилт

2.2 Их театр нь уран бүтээлч, соёлын ажилтны мэргэжлийн өндөр ур чадварт тулгуурлан, үндэсний урлагийн шилдэг бүтээл үндэсний дуурь, дуулалт жүжиг, үндэсний бүжгэн жүжиг /балет/ ардын дуу, бүжиг, хөгжмийн болон дэлхийн шилмэл бүтээлээр тус тус үйлчилнэ.

2.3 Үндэсний болоод дэлхийн улс үндэсний урлаг, соёлын ховор нандин өв, эх сурвалжийг эрэн сурвалжилж, байгууллагын сан хөмрөгт хадгалагдаж буй урлагийн бүтээлийг хадгалан хамгаалж, баяжуулж, мэдээллийн сан бий болгож зохих дүрэм, журмын дагуу ажиллуулна.

2.4. Их театр нь урлаг, театр судлалын чиглэлээр судалгааны ажил хийх, эрдэм шинжилгээний болон онол практикийн хурал, семинар зохион байгуулж, энэ чиглэлийн ном, гарын авлага, заавар зөвлөмж гаргаж бусад зэрэглэлийн театр, чуулгыг хангана.

2.5 Их театр нь судалгааны ажлын үр дүнгээ олон нийтийн хүртээл болгож, уран бүтээлдээ тусгах арга хэмжээ авна. Урлагийн олон төрөлт чиглэлээр судалгааны ажил хийж, сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллана.

2.6 Гадаад орны ижил төстэй байгууллагатай харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлж, өргөжүүлнэ.

2.7 Бүх шатны боловсролын сургалтын байгууллага, суралцагч-байгууллага, иргэнд зориулсан соёл, урлагийн боловсрол, танин мэдэхүйн ажлыг зохион байгуулна.

2.8 Нийт ажиллагсад уран бүтээлчдийн хэвийн ажиллах нөхцөл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, нийгмийн баталгааг хангахтай холбогдсон арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд анхаарч хөдөлмөр, нийгэм хамгааллын байгууллагатай хамтын гэрээ байгуулан ажиллана.

2.9 Их театр нь үйл ажиллагааныхаа хүрээнд зах зээлийн эдийн засгийн харилцааг төлөвшүүлэх, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, уран бүтээлийн чанар, үзвэр үйлчилгээний ажлын үр өгөөжийг дээшлүүлэн ажиллаж төсвийн хуульд заасны дагуу нэмэлт орлого олох боломж, бололцоог эрэлхийлнэ .

2.10 Монгол Улсын хууль тогтоомж, Их театрын дүрэм, хөдөлмөрийн дотоод журмыг зөрчсөн албан тушаалтан, ажилтанд хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд хариуцлага хүлээлгэж, сахилгын шийтгэл ногдуулна.

2.11 Их театрт албан ажлын чиглэлээр иргэд, ажилтнаас гаргасан санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч тогтоосон хугацаанд шийдвэрлэнэ.

2.12 Их театрын эзэмшилд байгаа төрийн болоод хамтын өмч хөрөнгийг зохистой ашиглах, хадгалан хамгаалах, ашиглалтын байдалд хамтын хяналт тавина.

2.13 Их театрын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг боловсруулах, биелэлтийг зохион байгуулахад шаардагдах бүртгэл тооцоо, судалгаа, мэдээ тайланг хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж нэгтгэн дүгнэнэ.

2.14 Их театрын үйл ажиллагаа, уран бүтээл, урын сан, уран бүтээлчдийн тухай гадаад дотоодод сурталчлах, тэргүүний уран бүтээлчдийг алдаршуулах, нөөц бололцоо, авьяас чадавхад тулгуурлан үйл ажиллагаагаа бие даан явуулна.

2.15 Мэргэжлийн урлагийн байгууллага нь өөрийн эзэмшил газраа байгууллагын үндсэн чиг үүрэгт харшлах, өөр зориулалтаар бусдад ашиглуулж, эзэмшүүлэхийг хориглоно. Мөн өөрийн эзэмшил, өмчлөлд байгаа төрийн өмчийг зориулалтын дагуу ашиглах, ашиглалтын байдалд хяналт тавих, хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авна.

### **Гурав. Удирдлага, зохион байгуулалт**

3.1 Төрийн өмчийн мэргэжлийн урлагийн байгууллагын дарга, захирлыг Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хууль тогтоомжид нийцүүлэн сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилж, чөлөөлнө.

3.2 Их театрын бүтэц бүрэлдэхүүн нь хэлтэс, алба, хэсгийн зохион байгуулалттай байна.

### 3.3 Захирлын чиг үүрэг

3.3.1 Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулах зохицуулалт, хяналтыг хариуцна.

3.3.2 Байгууллагын стратеги хөгжлийн болон дунд богино хугацааны үйл ажиллагааны хөтөлбөр, бизнес төлөвлөгөөг батлах.

3.3.3 Байгууллагын стратеги хөгжлийн болон дунд хугацааны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах удирдлага зохион байгуулалтын бүтцийг батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан батлах, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох.

3.3.4 Уран бүтээлч, албан хаагчдыг ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу нэр дэвшүүлэн сонгон шалгаруулалт явуулсны үндсэн дээр ажилд томилж, чөлөөлөх.

3.3.5 Батлагдсан төсвийг зариулалтын дагуу үр ашигтай захиран зарцуулах

3.3.6 Ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилд томилж, чөлөөлнө.

3.3.7 Байгууллагаа төлөөлж ижил, төстэй гадаад дотоодын байгууллага, иргэнтэй хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр байгуулна.

3.3.8 Мэргэжлийн ур чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлж, тэднийг сургах, мэргэшүүлэх, үр бүтээлтэй ажиллах нөхцөл бололцоогоор хангана.

3.3.9 Ажилтны нийгмийн болоод ажил мэргэжлийн холбогдолтой асуудлыг хүлээн авч, шийдвэрлэнэ.

3.3.10 Барилга байгууламж, тоног төхөөрөмж, сан хөмрөгийн аюулгүй байдлыг хангана.

3.3.11 Байгууллагын үйлчилгээний орчинг сайжруулах, байгууллагын үйл ажиллагаанд орчин үеийн шинжлэх ухаан, техникийн ололт, шинэ технологийг нэвтрүүлнэ.

3.3.12 Хууль тогтоомжид заасан бусад эрх

3.4 Захирлын дэргэд Захиргааны зөвлөл, Уран сайхны зөвлөл, Мэдээлэл, мэргэжил арга-зүйн зөвлөл ажиллана.

### 3.5 Захиргааны зөвлөлийн чиг үүрэг

3.5.1 Захиргааны зөвлөлийг алба, нэгжийн дарга нар, уран сайхны удирдагч, санхүү, хүний нөөцийн мэргэжилтнээс бүрдүүлж, дарга, захирлын тушаалаар баталгаажуулна.

3.5.2 Захиргааны зөвлөл нь байгууллагын стратеги хөгжлийн хөтөлбөр, дунд, богино хугацааны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн санал гаргаж удирдлагаар хангах, хэрэгжилтийг зохицуулах, хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх .

3.5.3 Захиргааны зөвлөл нь байгууллагын хөгжлийн дэд хөтөлбөрүүдийг хэлэлцэн, санал гаргах, хэрэгжилтийн тайлан мэдээг дүгнэх

3.5.4 Байгууллагын жил, хагас жил, улирал, сарын ажлын төлөвлөгөөг хэлэлцэн санал гаргах, хэрэгжилтийн үр дүнг тооцох, үнэлгээ дүгнэлт өгөх

3.5.5 Байгууллагын хэмжээнд нийтээр дагаж мөрдөх заавар, журам, хамтын гэрээний төслийг хэлэлцэн санал гаргах

3.5.6 Бүтцийн нэгжийн удирдах ажилтны хөдөлгөөн болон үр дүнгийн гэрээ, ажлын тайланг хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгөх

### 3.6. Уран сайхны зөвлөлийн чиг үүрэг

3.6.1 Уран сайхны зөвлөл нь байгууллагын урын сангийн бодлого, төлөвлөгөө, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, уран бүтээлийн жил, хагас жил, улирлын төлөвлөгөөг баталж, биелэлтэд хяналт тавих

3.6.2 Уран бүтээлчдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, хөгжүүлэх, хамтран ажиллах

3.6.3 Зөвлөл нь уран бүтээлийн хамт олны дунд мэргэжил ур чадвар, аттестатчлалын шалгалт зохион байгуулж, уран бүтээлчдийн ур чадварыг дээшлүүлэх, идэвхижүүлэх, ажлуудыг зохион байгуулах

3.6.4 Зөвлөлийн бүрэлдэхүүнийг орон тооны болон орон тооны бус мэргэжилтэн, ахмад, залуу уран бүтээлчдийн төлөөллийг оролцуулан, дарга, захирлын тушаалаар батална.

3.6.5 Уран сайхны зөвлөл нь уран бүтээлийн удирдлага бусад холбогдох хүмүүсээр бүрдэн, байгууллагын урын сангийн бодлого, шинээр хийх уран бүтээлийг сонгох, урын сан дахь уран бүтээлийг сэргээх, уран бүтээлчдийн мэргэжил, мэдлэг, ур чадварт үнэлэлт дүгнэлт өгөх

3.6.6 Уран сайхны зөвлөлийн дарга нь уран сайхны удирдагч байх бөгөөд тухайн байгууллагын үндсэн чиг үүрэгт нийцсэн мэргэжлийн өндөр ур чадвартай, туршлагатай, бусдад хүлээн зөвшөөрөгдсөн уран бүтээлч байна. Уран сайхны удирдагчийг захирал томилно.

### 3.7 Мэдээлэл, мэргэжил арга зүйн зөвлөлийн чиг үүрэг

3.7.1 Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг захирал батална.

3.7.2 Мэдээлэл, мэргэжил арга зүйн зөвлөлийн дарга нь гадаад улс оронд мэдлэг дээшлүүлж, туршлага хуримтлуулсан, бусад уран бүтээлчид ажиллагсаддаа үлгэр дууриал болохуйц мэргэжлийн өндөр ур чадвартай, уран бүтээлч хүн байна.

3.7.3 ММАЗЗөвлөл нь Их театраас бусад урлаг, уран бүтээлийн байгууллагад арга зүйн зөвлөмж өгөх, урлагийн боловсролын хөтөлбөр, бодлого боловсруулах, хэрэгжүүлэхдээ Маркетингийн албатай нягт хамтран ажиллах үүрэгтэй.

3.7.4 Зөвлөлийн бүрэлдэхүүн нь орон тооны бус, ажиллах журмын дагуу үйл ажиллагаанд оролцоно.

## **Дөрөв. Байгууллагын баримт, архив, урын сан, өвийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт**

4.1 Мэргэлжийн урлагийн байгууллагын бичиг баримтын бүрдүүлэлт, архивын нэгжийг архивын тухай хууль, “Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичиг”MNS5140-1:20118 MNS5140:2:2011, стандарт, “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ыг тус тус мөрдөн бүрдүүлнэ.

4.2 Үндэсний болоод гадаадын урлаг, соёлын ховор нандин өв, эх сурвалжийг эрэн сурвалжилж, сан хөмрөгт хадгалагдаж буй нот клави́р, партитурыг электрон хэлбэрт оруулж, тоглогдож байгаа бүтээлийг баримтжуулан, аудио, видео бичлэг хийж каталог (MNS5638:2006)-жуулна.

4.3 Сан хөмрөгт хадгалагдаж байгаа нот, клави́р, партитур, аудио, видео бичлэгийг номын сангийн анхан шатны бүртгэл (БСШУСайдын 2005 оны 411 дүгээр тушаал)-д оруулж, хөрөнгийн бүртгэлд тусгана.

4.4 Сан хөмрөгт хадгалагдаж байгаа нот, клави́р, партитур, номын техник ажиллагааг бүрэн хийж каталог (MNS5639:2006)–жуулан үйлчлүүлэгчдэд ашиглуулах боломж нөхцлийг бүрдүүлнэ.

4.5 Уран бүтээл, ажилтны ажиллах таатай нөхцөл, хөдөлмөр хамгааллын аюулгүй байдлыг хангаж, ажиллагсдын хөдөлмөр, аюулгүйн үйл ажиллагааны болон эрх зүйн талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлж, уулзалт-семинар зохион байгуулж, мэдээллээр хангана.

4.6 Байгууллагын эд хогшил, тайз чимэглэл, хувцас, гэрэл, дуу чимээний хэрэгслийн ашиглалтыг сайжруулах, материаллаг баазыг бэхжүүлж байгууллагын эзэмшилд байгаа төрийн өмчийг зөв зохистой ашиглах, ашиглалтын байдалд хяналт тавьж, оюуны өмч, зохиогчийн эрхийг дээдлэн ажиллана.

4.7 Байгууллагын шинээр болон сэргээх уран бүтээлийг найруулагчийн төлөвлөгөө, хувцасны загвар (эскиз), тайз, хувцас, нүүр будгийн загвар, макет, жүжгийн зохиол, дүрс бичлэг, фото, жүжгийн гэрэл, хөгжим чимэглэлийн дараалал (партитур), тэмдэглэл зэрэг баримтыг бүрдүүлж байгууллагын архивт хадгална. Зарим томоохон бүтээлийн холбогдох материалын нэг хувийг Театрын музейд шилжүүлнэ.

4.8 Урын сан, архив, театрын музейд шилжүүлэх баримт материал нь бүрэн цэгцлэгдсэн Их театрын уран сайхны зөвлөлөөр батлагдсан байна.

4.9 Байгууллагын уран бүтээлийн урын санг эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулж ашиглах боломжийг хангана.

4.10 Урын санг нэр төрөл, он цаг, ач холбогдол, хадгалах хугацаагаар нь ангилан хадгаламжийн нэгж бүрдүүлнэ.

4.11 Их театрын төсөв хөрөнгө, улсын төсөв болон хандив тусламжаар бүтээсэн бүтээл нь байгууллагын өмч бөгөөд Монгол улсад дагаж мөрдөж байгаа хууль, журмаар хамгаалагдана.

### **Тав. Эд хөрөнгө, санхүү**

5.1 Их театрын эд хөрөнгө нь дор дурдсан зүйлээс бүрдэнэ:

5.1.1 Байгууллагын сан хөмрөгт бүртгэгдсэн эд зүйл,

5.1.2 Байгууллагын үндсэн хөрөнгөд тусгагдсан барилга, тоног төхөөрөмж, эд хогшил

5.1.3 Байгууллага иргэдээс хандивласан, бэлэглэсэн эд зүйл, тоног төхөөрөмж

5.2. Театр, чуулгын санхүүжилт дор дурдсан эх үүсвэрээр бүрдэнэ:

5.2.1 Улсын төсөв

5.2.2 Өөрийн үйл ажиллагааны орлого

5.2.3 Байгууллагын үйл ажиллагааг дэмжсэн гадаад, дотоодын байгууллага, иргэдээс өгсөн хандив, тусламж:

5.2.4 Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад орлого

5.3 Байгууллагад хандивласан хөрөнгийг байгууллагын санхүүгийн тайланд тусгаж, зориулалтын дагуу ашиглана. Хандивласан хөрөнгө нь хууль ёсны эх үүсвэртэй байна.

### **Зургаа. Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах ба хүчин төгөлдөр болох**

6.1 Байгууллагын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачлагыг захиргааны зөвлөл, уран сайхан, мэдээлэл, мэргэжил-арга зүйн зөвлөл болон ажилтан, уран бүтээлч гаргаж болно.

6.2. Байгууллагын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж батлах бөгөөд баталсан тухай шийдвэр гаргаснаар хүчин төгөлдөр болно.

## **Долоо. Бусад зүйл**

7.1 Их театрын үйл ажиллагааны бусад харилцааг байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, уран бүтээлчид, ажилтантай хийсэн хөдөлмөрийн гэрээ хэлэлцээрээр зохицуулна.

7.2 Байгууллагын дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудлыг захиргаа, уран сайхан, мэдээлэл, мэргэжил- арга зүйн зөвлөлийн удирдлагын гишүүдийн олонхийн саналыг үндэслэн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

7.3 Энэхүү дүрэм нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, даган мөрдөнө.